


## 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### ЦЭХ-НИЙ БОЛОВСРУУЛАЛТ-



2024 оны гүйцэтгэлээр 175.1 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулснаас дотоод хэрэгцээндээ 19.82 сая кВт.ц буюу 11.31 хувийг нь зарцуулан 155.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч түгээж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 107%-н гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.




График 1. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт

### ЦЭХ –НИЙ ТҮГЭЭЛТ:

145175.4 мян квт ц ЦЭХ түгээсэн нь төлөвлөгөөнөөс 10189 мян квт ц-аар илүү буюу 107.0% биелсэн ба урьд оноос 21934.7 мян квт ц эрчим хүч илүү түгээж 116.4 %-н гүйцэтгэлтэй гарсан байна. Станц түүхэндээ 2018 онд хамгийн өндөр ЦЭХ-ний боловсруулалт 161.4 сая кВт, түгээлт 140.1 сая кВт хийгдэж байсан бол энэ онд 13.8 сая кВт-аар илүү боловсруулалт, 15.3 сая кВт-аар илүү түгээлт хийж хамгийн өндөр ЦЭХ-ний боловсруулалт, түгээлттэй жил болж байна.




График 2. Цахилгаан эрчим хүчний түгээлт

## ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР



График 3. ДЭХ-ний түгээлт/Гкал/

Тайлант онд усаар 202202 Гкал, уураар 58603Гкал, нийт 260805 Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 9253 Гкал илүү түгээж төлөвлөгөөний биелэлт 103.7 % байна. Диспетчерийн графикийн зөрчилгүй ГОТ 100 % биелсэн. Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 3232 Гкал бага түгээж 98.8 %-н биелэлттэй байна.

Дулааны түгээлтийн бүтцийг харуулбал: Нийт дулааны түгээлтийн 74.7 хувийг буюу 194875 Гкал-ыг УБДС ХК, хэрэглэгчдэд 2.8 хувь буюу 7327 Гкал, уураар 22.5 хувь буюу 58603 Гкал тус тус түгээсэн байна.

Дулааны эрчим хүчний түгээлтийн биелэлтийг сар бүрээр графикаар харуулбал:




График 4. Дулааны эрчим хүчний түгээлт/усаар/

### Уурын дулааны түгээлт:




График5. Уураар түгээсэн дулааны эрчим хүч

2024 онд уураар 58603 Гкал дулаан түгээсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 16603 Гкал-аар өссөн, өмнөх онтой харьцуулахад 4261 Гкал-аар буурсан байна.

### ДХЦЭХ:

2024 оны гүйцэтгэлээр нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 11.31 хувь буюу 19.82 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэрэгцээндээ зарцуулсан нь төлөвлөгөөнөөс 576 мян кВт.ц буюу 1.01 хувиар буурсан байна.






График 7. ДХЦЭХ

Энэ онд дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч 11.31 хувь гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 1.13 хувиар буурсан, ЭХЗХ-ны баталсан төлөвлөгөөнөөс 1.01 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан. ДХЦЭХ-ний хувь хэмжээ энэ онд буурсан үзүүлэлттэй байгаа тоноглолын ачаалал авалт сайжирч түгээлт нэмэгдсэнээр хувь хэмжээ буурч харагдаж байна. Биетээр төлөвлөсөн хэмжээнээс 576 мян кВт-аар буурсан ба өмнөх оноос 850 мян кВт-аар өссөн энэ нь үндсэн тоноглолын ажилласан цаг өмнөх жилүүдээс өндөр байгаа тул биет хэмжээ нэмэгдэж байна.



## ЖИШМЭЛ ТҮЛШНИЙ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ, НҮҮРСНИЙ ЗАРЦУУЛАЛТ

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2024 онд ЦЭХ-нд 549.42 гр/кВт.ц гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 46.8 гр/кВт.ц-аар, төлөвлөсөн хэмжээнээс 65.8 гр/кВт.ц-аар тус тус хэмнэж, дулаанд 193.47 кг/Гкал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 3.9 кг/Гкал-аар, төлөвлөгөөнөөс 7.1 кг/Гкал-аар тус тус буурч нийлбэр дүнгээр 3958.7 тн жишмэл түлш хэмнэсэн буюу бодит нүүрсээр 12292 тн хэмнэсэн




График 8. Жишмэл түлшний хувийн зарцуулалт

Түлшний хувийн зарцуулалт хэмнэсэн шалтгаан нь:

- Конденсатын алдагдал 0.5%-иар буурсан
- Вакум 3.3%-иар нэмэгдсэн.
- Тэжээлийн усны температур 9.2°C-ээр нэмэгдсэн.
- Уурын хувийн зарцуулалт 0.05кг/кВт-аар буурсан
- Үндсэн тоноглолын зогсолт зуух-11-ээр, турбин 16-аар буурсан
- Нүүрсний дулаан гаргах чадвар төлөвлөсөн хэмжээнээс 68 ккал/кг-аар нэмэгдсэн.
- РОУ-н зарцуулалт 71699 тн-оор буурсан.

## 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### Зорилтод түвшин:

| Үзүүлэлтүүд                 | х.н      | 2023 оны мөн үеийн гүйцэтгэл | Тайлант он |        | Хувь        |         |
|-----------------------------|----------|------------------------------|------------|--------|-------------|---------|
|                             |          |                              | Төл        | Гүйц   | Өмнөх оноос | Төл-өөс |
| Боловсруулсан ЦЭХ           | сая.квтц | 152.4                        | 165.6      | 175.2  | 115%        | 106%    |
| ДХЦЭХ                       | Биетээр  | сая.квтц                     | 19.0       | 20.4   | 104%        | 97%     |
|                             | Хувиар   | хувь                         | 12.4%      | 12.3%  | 91%         | 92%     |
| Эрчим хүч түгээлт Цахилгаан | сая.квтц | 133.4                        | 145.2      | 155.36 | 116%        | 107%    |
| Дулаан                      | мян.Гкал | 264.0                        | 251.6      | 260.8  | 99%         | 104%    |

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

|                                    |         |          |          |          |       |      |
|------------------------------------|---------|----------|----------|----------|-------|------|
| Нийт орлого                        | сая.төг | 34,499.5 | 37,383.6 | 39,096.5 | 113%  | 105% |
| Үүнээс: Цэвэр борлуулалт           | сая.төг | 34,138.5 | 37,076.3 | 37,804.0 | 111%  | 102% |
| Нийт зардал                        | сая.төг | 34,488.8 | 39,568.8 | 38,975.6 | 113%  | 99%  |
| Үүнээс: Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 170.5    | 194.0    | 417.9    | 245%  | 215% |
| Ашиг / алдагдал /                  | сая.төг | 10.7     | -2,185.2 | 121.0    | 1130% | -6%  |
| Цэвэр ашиг / алдагдал /            | сая.төг | 7.4      | -2,185.2 | 106.1    | 1444% | -5%  |
| Борлуулалтын 1 төг-т ногдох зардал | төг     | 1.0      | 1.1      | 1.0      | 100%  | 94%  |
| Авлага                             | сая.төг | 1,280.3  | 1,365.0  | 1,651.9  | 129%  | 121% |
| Өглөг                              | сая.төг | 1,839.1  | 1,263.7  | 1,276.4  | 69%   | 101% |
| Үүнээс: Богино хугацаат өглөг      | сая.төг | 1,483.5  | 950.0    | 962.6    | 65%   | 101% |
| ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал           | сая.төг | 2,609.7  | 3,313.5  | 2,215.2  | 85%   | 67%  |
| Жишмэл түлшний зарцуулалт ЦЭХ      | гр/кВтц | 596.2    | 615.3    | 549.4    | 92%   | 89%  |
| ДЭХ                                | кг/Гкал | 197.3    | 200.6    | 193.5    | 98%   | 96%  |
| Нийт ажиллагсдын тоо               | тоо     | 280      | 311      | 290      | 104%  | 93%  |
| Нийт цалингийн сан                 | сая.төг | 10,295.2 | 13,866.9 | 13,292.2 | 129%  | 96%  |

## 1. Нийт орлого:

Тайлангийн хугацаанд: Цахилгаан эрчим хүчний орлого 30,485.2 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 3,653.3 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 361.0 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн 34,499.5 сая.төг байна. Нийт борлуулалтын орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 2,079.8 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 89.3 хувийг ЦЭХ-ний, 10.7 хувийг ДЭХ-ний орлого эзэлж байна.

2023 онд үйл ажиллагааны бус орлогоор 250.0 сая төг олохоор төлөвлөн 361 сая төгрөг олж төлөвлөгөөг 111.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.


## 2. Нийт зардал:

Зардлын задаргаа:

| Зардлын төрөл                     | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     | Зөрүү       |
|-----------------------------------|---------------|---------------|-------------|
| Түлшний зардал                    | 14,873,200.05 | 14,736,962.66 | -136,237.38 |
| Шатахууны зардал                  | 306,305.9     | 233,215.1     | -73,090.86  |
| Урсгал засвар                     | 572,997.2     | 723,221.8     | 150,224.59  |
| Үндсэн ба нэмэгдэл цалин          | 13,752,616.02 | 13,152,814.61 | -599,801.41 |
| Бусад зардлууд                    | 4,385,771.66  | 4,251,780.21  | -133,991.45 |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 4,489,140.00  | 4,338,350.10  | -150,789.90 |

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

|                                   |                      |                      |                    |
|-----------------------------------|----------------------|----------------------|--------------------|
| Ажиллагсдын нийгмийн зардал       | 994,809.15           | 1,121,292.91         | 126,483.76         |
| <b>Үйл ажиллагааны бус зардал</b> | <b>194,000.0</b>     | <b>417,927.9</b>     | <b>223,927.86</b>  |
| <b>Нийт дүн</b>                   | <b>39,568,840.03</b> | <b>38,975,565.23</b> | <b>-593,274.80</b> |



3. Ашиг алдагдал:

| Үзүүлэлт                           | Хэмжих нэгж | Өссөн дүнгээр |           |          |
|------------------------------------|-------------|---------------|-----------|----------|
|                                    |             | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл | Зөрүү    |
| Үйл ажиллагааны ашиг алдагдал      |             |               |           |          |
| Нийт орлого                        | сая.төг     | 37,076.31     | 37,803.97 | 727.67   |
| Нийт зардал                        | сая.төг     | 39,374.84     | 38,557.64 | -817.20  |
| Ашиг, алдагдал                     | сая.төг     | -2,298.53     | -753.66   | 1,544.87 |
| Үйл ажиллагааны бус ашиг алдагдал  |             |               |           |          |
| Үйл ажиллагааны бус орлого         | сая.төг     | 307.30        | 1,292.55  | 985.25   |
| Үйл ажиллагааны бус зардал         | сая.төг     | 194.0         | 417.9     | 223.93   |
| Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал | сая.төг     | 113.30        | 874.63    | 761.33   |
|                                    |             | (2,185.23)    | 120.96    | 2,306.20 |

Нийт ашиг 120.9 сая төгрөг гарсан бөгөөд цэвэр ашиг 106.1 сая төгрөг гарч нийт алдагдлыг 2,291.3 сая төгрөгөөр бууруулсан байна.